



I-V/2021


Тархаасан: 2021 оны 6 дугаар сарын 13



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх сараас 5.9 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2021 оны 5 дугаар сард урьдчилсан гүйцэтгэлээр 163.1 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 31.4 хувь, өмнөх сараас 5.9 хувиар түс түс өссөн байна.


Зураг 1. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100), сараар, хувь



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2021 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 31.4 хувиар өсөхөд уул уурхай, олборлолтын дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 38.5 хувиар (чүлүүн, хүрэн нүүрс олборлолтын үнэ, 4.4 хувь, газрын тос, байгалийн хий олборлолтын үнэ 90.3 хувь, металын хүдэр олборлолтын үнэ 30.8 хувь, бусад ашигт малтмал олборлолтын үнэ 10.4 хувь) өссөнөөс шалтгаалсан байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2021 оны 5 дугаар сард өмнөх сараас 5.9 хувиар өсөхөд уул уурхай, олборлолтын дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 6.8 хувиар (чүлүүн, хүрэн нүүрс олборлолтын үнэ 8.7 хувь, газрын тос, байгалийн хий олборлолтынх 4.6 хувь, металлын хүдэр олборлолтынх 7.6 хувь, бусад ашигт малтмал олборлолтын үнэ 1.8 хувь) өссөнөөс голлон нөлөөлжээ.

Зураг 2. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлтөд дэд салбаруудын оролцооны түвшин, нэгжээр, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 31.4 хувиар өсөхөд уул уурхай, олборлолтын салбарын үйлдвэрлэгчийн үнэ 30.1 нэгж, боловсруулах үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 1.0 нэгж, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын үйлдвэрлэгчийн үнэ 0.3 нэгжээр нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, дэд салбараар, хувиар, 2021 оны 5 дугаар сард

Дэд салбар	Нийт жин	<u>2021* V</u>	<u>2021* V</u>	<u>2021* V</u>
		2015	2020 V	2021 IV
		2015=100		
Ерөнхий индекс	100.0	163.1	131.4	105.9
Уул уурхай, олборлолт	77.9	172.5	138.5	106.8
Боловсруулах үйлдвэрлэл	14.6	135.4	106.4	100.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	6.7	115.0	105.5	105.9
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.8	147.3	100.2	100.0

Ойлголт, тодорхойлолт:

Үйлдвэрлэгчийн үнийн индекс(ҮҮИ): Тухайн үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн болон худалдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Индексийн жин: Индексийн тооцоонд ашиглах жинг тухайн бүтээгдэхүүний нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувийн жингээр тооцно.

Тооцох аргачлал:

ҮҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийг хэрэглэнэ.Үүнд:

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n (p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^n (p_0^i * q_0^i)}$$

I_p^L - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t – Тайлант үе

0 – Суурь үе

p_t^i – i барааны тайлант үеийн үнэ

p_0^i – i барааны суурь үеийн үнэ

q_0^i - i барааны суурь үеийн худалдан авсан тоо

Эх үүсвэр: ҮСХ, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал,
Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал



Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 7 дугаар сарын 19

Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Б.Энхтүвшин
Утас : (976-51)-261561